Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Мэргэжлийн болон техникийн боловсролын газар

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | - | - | - | - | | Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд: 1. 2025 оны 2 дугаар сарын 10-14 хооронд төрийн өмчийн 31 сургалтын байгууллагад хөндлөнгийн үнэлгээ хийж үр дүнг танилцуулсан. Үүний үр дүнд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлж, | 70% | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | /тусгайлан/ | | | | | үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшуулал олгох журмын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулсан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилттэй нь холбож шалгуурыг боловсрууллаа. Энэ журмын төслийг боловсруулан ажиллаж байна. 2.Боловсролын сайд, Сангийн сайдын хамтран батлах Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын орон тооны хязгаарын жишигт нормативын төслийг батлуулахаар Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр 28-ны өдрийн 1/1716 тоот албан бичгээр 4 хувь батлуулахаар хүргүүлэв. 3.Боловсролын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгах саналыг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон салбарын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан боловсруулж, Боловсролын сайдын 2024 оны 01 дүгээр сарын15-ны өдрийн 1/179 дугаартай албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлэв. Монгол Улсын Их | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г хэлэлцэн батлав. "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам”, “Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлагыг төсөлд санал аван хэлэлцүүлэн дахин боловсруулж байна. Хавсралт: 5 файл | | |
| 1.1.1 | Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг шинэчлэн батлуулна. | - | Журамд нэмэлт оруулах төсөл боловсруулалтын хувь | - | 100 | 100 | Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмын төсөл боловсруулж байна. 5 сарын эхний 7 хоногт газар дотроо санал авах, мөн сургалтын менежерүүдэд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн ч хариуцсан албан хаагч 2025 оны 05 дугаар сарын 30-нд ажлаас чөлөөлөгдөв. | 50% | 50 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.2 | Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлж, үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшуулал олгох журмыг шинэчлэн батлуулна. | - | Журмын төслийн боловсруулалтын хувь | Боловсролын сайдын 2024.12.13-ны өдрийн А/246 дугаар тушаал-Аргачлал батлах тухай | 50 | 100 | Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.4 дэх хэсэг, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам” 25 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны “Хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүр, журам батлах тухай” 466 дугаар тогтоол, Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Аргачлал батлах тухай” А/246 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг 2025.02.10-14-ний өдрийг дуустал Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулав. Мэргэжлийн болон техникийн боловсролын төрийн өмчийн 31 сургалтын байгууллагад 15 мэргэжлийн чиглэл/хөтөлбөр, 2133 суралцагчид түүврээр сонгогдсоноос үнэлгээнд хамрагдсан 1960 суралцагч (173 суралцагч өвчтэй, | 50% | 50 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чөлөөтэй шалтгаантай үнэлгээнд оролцоогүй), ажил олгогч байгууллагын төлөөлөл 186 үнэлгээний ажилтан, хөндлөнгийн баталгаажуулагч 31, сургалтын байгууллагын болон аймаг нийслэлийн боловсролын газрын үнэлгээний багийн 270 гаруй албан хаагчид ажиллав. Одоогоор 31 сургалтын байгууллагын үнэлгээний эцсийн тайланг Боловсролын үнэлгээний төв боловсруулан ажиллаж байна. Сайдын тушаалаар 2024 оны 12 сарын А/246 дугаар тушаалаар Аргачлал батлуулан 2025 оны 2 дугаар сарын 10-14 хооронд төрийн өмчийн 31 сургалтын байгууллагад хөндлөнгийн үнэлгээ хийж үр дүнг танилцуулсан. Үүний үр дүнд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, чанар, үр дүнг үнэлж, үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшуулал олгох журмын шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулсан, гүйцэтгэлд суурилсан санхүүжилттэй нь холбож шалгуурыг боловсруулллаа. Энэ журмын төслийг боловсруулан ажиллаж байна.<br>Хавсралт: 2 файл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.3 | Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын орон тооны хязгаарын жишиг нормативыг боловсруулж батлуулна. | - | Орон тооны хязгаарын жишиг нормативын төсөл боловсруулалтын хувь | 50 | 70 | 100 | 1.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын орон тооны хязгаарын жишиг нормативын төслийг 2025 оны 01, 02 дугаар сарууддад судлан боловсруулсан. 2.Боловсролын сайд, Сангийн сайдын хамтран батлах Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын орон тооны хязгаарын жишигт нормативын төсөлд Сангийн сайдаас 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01/1154 тоот хариу албан бичиг ирсэн. Үүний дагуу нормативын төслийг сайжруулсан. Харин төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх тооцооллыг гаргаж дэмжлэг үзүүлэхийг Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэв. 3.2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын орон тооны хязгаарын жишиг нормативыг цахимаар хэлэлцүүлсэн. 4.Сангийн яам, төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудаас санал аван эцэслэн Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр 28-ны өдрийн 1/1716 тоот албан | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичгээр 4 хувь батлуулахаар хүргүүлэв. 2025 оны 06 дугаар сард багтаан батлуулах нь Засгийн газрын томилгоо, шийдвэрээс хамаарах нөхцөл байдал үүсэв. Хавсралт: 4 файл | | |
| 1.2. | Боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл боловсруулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, боловсролын чанарын үнэлгээ болон насан туршдаа | - | - | - | - | | Дараах бодлогын баримт бичгүүдэд саналаа өгөв. 1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө-2026, 2.ГБХНЯ-ны ”Хөгжлийн гүүр” туршилтын төсөл батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, 3.ХХААХҮЯ-ны ”Хангайн бүсэд хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, 4. “2026 оныг “Боловсролыг дэмжих жил болгон зарлах тухай” тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл, салбар дундын дадлагын бааз зэргээр төсөвт шаардлагатай зардлыг 5.Яамны үйл ажиллагааны аудиттай холбоотойгоор СХОГ-аас ирүүлсэн журмын хэрэгжилтийн явцын тайланг нотлох баримт, 4.Худалдан авах ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй төслийн 36.1.16-д “тогтоосон жишиг үнийн дагуу мэргэжлийн болон техникийн боловсролын | 100 % | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын чиглэл боловсруулах | | | | | сургалтын байгууллагын үйлдвэрлэсэн чанар, стандартын шаардлага хангасан бараа худалдан авах” гэж нэмж тусгах, 6.Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны салбарын мэдээлэл, илтгэл 7.Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан орон нутгийн иргэдэд нарийн мэргэжил эзэмшүүлэх Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэх хүрээнд бүс бүсээр нь тодорхойлох, 8.Чадамжийн төв, дадлагын баазад тавих нийтлэг шаардлагын төсөл, 9.Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам"-ын төсөл, 8.“Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”, “Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлын өөрийн үнэлгээний асуумж”, “Боловсролын сургалтын байгууллага болон сүм хийдийн орчны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө” 10.Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар бүхий “Олон улсын “PISA-2025” үнэлгээний бэлтгэл хангах, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгуулах тухай” албан даалгаврын дагуу Мэргэжлийн болон техникийн боловсролын доорх 19 сургалтын байгууллагын 123 багш, 2009 онд төрсөн 1-р курсийн нийт 840 суралцагч түүврээр сонгогдон үнэлгээнд хамрагдаад байна.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.2.1 | PISA - 2025 олон улсын сурлагын амжилтын судалгааг зохион байгуулах бэлтгэлийг хангаж, судалгааны ажлыг удирдлага, зохицуулалтаар хангана. | 767,500.00(боловсролын бүх түвшинд) | PISA-2025 үнэлгээний үндсэн судалгаанд хамрагдсан суралцагчийн хувь (192 сургуулийн 7450 суралцагч) (18 мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хамрагдсан суралцагчийн хувь) | - | 50 | 100 | Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар бүхий “Олон улсын “PISA-2025” үнэлгээний бэлтгэл хангах, зохион байгуулах тухай” албан даалгаврын дагуу Мэргэжлийн болон техникийн боловсролын доорх 19 сургалтын байгууллагын 123 багш, 2009 онд төрсөн 1-р курсийн нийт 840 суралцагч түүврээр сонгогдон үнэлгээнд хамрагдав. 1. Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургууль 2. Говьсүмбэр Политехник коллеж 3. Дархан-Уул аймаг дахь Дархан политехник коллеж 4. Дорнод аймаг дахь политехник коллеж 5. Орхон аймаг дахь политехник коллеж 6. Өвөрхангай аймаг дахь политехник коллеж 7. ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургуулийн харьяа политехник коллеж 8. ШУТИС-ийн харьяа Хөвсгөл | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймаг дахь политехник коллеж 9. Барилгын политехник коллеж 10. Техник технологийн политехник коллеж 11. Барилга, технологийн политехник коллеж 12. ТОП мэргэжлийн боловсролын сургууль 13. Налайх дүүрэг дэх политехник коллеж 14. Их Засаг мэргэжлийн боловсролын сургууль 15. Үйлдвэрлэл урлалын политехник 16. Монгол-Солонгосын политехник коллеж 17. Хангай мэргэжлийн боловсролын сургууль 18. Хүнс, технологийн политехник коллеж 19. Төв аймгийн Баянчандмань суман дахь политехник коллеж "PISA-2025" үнэлгээний тайлан Боловсролын үнэлгээний төвд нэгтгэгдэж байна<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.2.2 | Монгол Улсын 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан батлуулна. | - | Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгах саналын төсөл боловсруулалтын хувь | - | 100 | - | Боловсролын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/05 дугаар тушаалаар Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажилласан. Тус ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгах саналыг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон салбарын | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тэргүүлэх чиглэлтэй уялдуулан боловсруулж, Боловсролын сайдын 2024 оны 01 дүгээр сарын15-ны өдрийн 1/179 дугаартай албан бичгээр Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн. Ажлын хэсгийн дараагийн хийх ажил нь А/05 тушаалын 1-т заасны дагуу 2026 оны төлөвлөгөөнд тусгах саналын тайлбар, үндэслэлийг Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г хэлэлцэн батлав<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.2.3 | "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам болон шинжээчид тавих шаардлага"- | - | Журам, шаардлагын төсөл боловсруулалтын хувь | 50 | 70 | 100 | Биелэлт "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам”, “Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага”-ын төслийг тус тус боловсруулж, яамны цахим хуудсанд байршуулан олон нийтээс санал авч, шинэчлээд Боловсролын сайдын 2025 оны 1/1041 тоот албан бичгээр | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ыг боловсруулж батлуулна. | | | | | | Монголын Хуульчдын холбоонд журам, шаардлагын төслийг хүргүүлж, ирүүлсэн саналын хүрээнд хэлэлцүүлэг яамны холбогдох газар, хэлтэс, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн төлөөллийг оролцуулан 2025.05.29-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, журам шаардлагын төслийг яамны албан хэрэг хөтлөлтийн систем /365/-д оруулан холбогдох нэгжийн дарга нарт танилцуулан санал авч байна. Хавсралт: 3 файл | | |
| 1.2.4 | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, шаардлагатай баримт бичгийг батлуулан Төслийн удирдах хорооны | - | Арга хэмжээний тоо | 2024 оны гүйцэтгэл | 1 | 1 | 1.Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт төслийн Төлөөлөн удирдах хорооны 2025 оны хурлын бэлтгэл ажлыг хангаж тус төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан засварлах, гишүүдэд хурлын зар, мэдээлэл бэлтгэн хүргүүлэв. 2.Боловсролын яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн хамтран хэрэгжүүлж буй “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт II” төслийн удирдах хороо 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж, 2024 онд | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана. | | | | | | хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн болон 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэв. Төслийн удирдах хорооны хуралд Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Австралийн Элчин Сайдын Яамны дэд тэргүүн Эндрю Бэрримэн, Холбооны Бүгд Найрамдах Холбооны Герман Улсын Элчин Сайдын Яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн ажиллагааны хэлтсийн дарга Удо Вебер, МҮХАҮТ-ын ерөнхийлөгч Л.Төр-Од болон бусад гишүүд оролцлоо. 3.Монгол Улсын Боловсролын яамны нэрийн өмнөөс Ази, Номхон далайн бүсийн орнуудын хүний нөөцийн хөгжлийн Засгийн газар хоорондын байгууллага (CPSC) -д Монгол Улсын Боловсролын яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын даргаар Н.Нарангэрэл 2025 оны 05 дугаар сарын 07-ний өдрөөс эхлэн томилогдон ажиллах талаар албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 8/2083 тоот албан бичгийг cpsc@cpsctech.org мэйл хаяг руу илгээв. 4.2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр "Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн "Түншлэлд суурилсан Техникийн болон | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэргэжлийн Боловсрол, Сургалт төсөл”-ийн зөвлөх багаас зохион байгуулсан мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын санхүүжилт, гүйцэтгэлийн санхүүжилт, жендерийн шалгуур үзүүлэлт боловсруулах уулзалт, хэлэлцүүлэгт Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адьяасүрэнгийн хамтаар Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын бүх албан хаагчид оролцож, санал зөвлөмжөө өгч ажиллав. Хавсралт: 4 файл | | |
| 1.3. | Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт, шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг | - | - | - | - | | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн агуулгад Боловсролын Ерөнхий Хуулийн 14.4-д тусгагдсан заавал тусгах агуулгыг тухайн мэргэжлийн хөтөлбөрт мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хөтөлбөрийн 60-80 хувьд нь олгож байсныг өөрчлөн “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт заавал тусгах агуулгыг 100 хувь судлахаар боловсруулав. Мөн сургалтын хөтөлбөрийн заавал тусгах агуулгын хүрээг нарийвчлан судлах, цаг нэмэх, шинэчлэн сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага үүсэж “Мэргэжлийн болон техникийн боловсролын | 100 % | 70 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлнэ. | | | | | сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загвар”-т заавал тусгах агуулгад авлигаас урьдчилан сэргийлэх, шударга, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлэхтэй холбоотой агуулгыг Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх, Амьдрах ухааны ур чадварыг эзэмших зэрэг Чадамжийн нэгжид тусгасан боловсруулан баталж 2024-2025 оны хичээлийн жилээс нийт 69 сургалтын байгууллага хөтөлбөрийн агуулгаа шинэчлэв. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын “Үндэсний бичиг-бидний бахархал” улсын IV уралдааныг 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 02-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж үндэсний бичгийн сургалт, судалгааны асуудлаар илтгэл, хэлэлцүүлэг хийв. Тус арга хэмжээг Шинэ иргэншил политехник коллеж санаачлан Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Боловсролын ерөнхий газар, Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн, Архивын ерөнхий газар, Боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судалгааны үндэсний хүрээлэн зэрэг байгууллагууд, эрдэмтэн судлаач, багш нар идэвх санаачилгатай дэмжин ажиллав. Үндэсний бичгийн үүсэл, хөгжлийн асуудлаас эхлэн өнөөдрийн түвшинд төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах хүртэл хөгжиж ирсэн туршлага, үндэсний бичгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг олон талаас нь хөндлөө. Тус уралдаанд мэргэжлийн болон техникийн боловсролын 32 сургалтын байгууллагын 100 гаруй багш оролцов. Хавсралт: 3 файл | | |
| 1.3.1 | Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулгыг тусгаж хэрэгжүүлнэ. | - | Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох нийтлэг агуулгыг тусган шинэчлэн боловсруулж, тухайн онд баталсан хөтөлбөрийн тоо | - | - | 8 | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн агуулгад Боловсролын Ерөнхий Хуулийн 14.4-д тусгагдсан заавал тусгах агуулгыг тухайн мэргэжлийн хөтөлбөрт мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хөтөлбөрийн 60-80 хувьд нь олгож байсныг өөрчлөн “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт заавал тусгах агуулгыг 100 хувь судлахаар боловсруулав. Мөн сургалтын хөтөлбөрийн заавал тусгах агуулгын хүрээг нарийвчлан судлах, цаг нэмэх, шинэчлэн сайжруулалт хийх хэрэгцээ | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шаардлага үүсэж “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загвар”-т заавал тусгах агуулгад авлигаас урьдчилан сэргийлэх, шударга, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлэхтэй холбоотой агуулгыг Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх, Амьдрах ухааны ур чадварыг эзэмших зэрэг Чадамжийн нэгжид тусгасан боловсруулан баталж 2024-2025 оны хичээлийн жилээс нийт 69 сургалтын байгууллага хөтөлбөрийн агуулгаа шинэчлэв. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын “Үндэсний бичиг-бидний бахархал” улсын IV уралдааныг 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 02-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж үндэсний бичгийн сургалт, судалгааны асуудлаар илтгэл, хэлэлцүүлэг хийв. Тус арга хэмжээг Шинэ иргэншил политехник коллеж санаачлан Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Боловсролын ерөнхий газар, Шинжлэх ухааны академийн Хэл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохиолын хүрээлэн, Архивын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн зэрэг байгууллагууд, эрдэмтэн судлаач, багш нар идэвх санаачилгатай дэмжин ажиллав. Үндэсний бичгийн үүсэл, хөгжлийн асуудлаас эхлэн өнөөдрийн түвшинд төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах хүртэл хөгжиж ирсэн туршлага, үндэсний бичгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг олон талаас нь хөндлөө. Тус уралдаанд мэргэжлийн болон техникийн боловсролын 32 сургалтын байгууллагын 100 гаруй багш оролцов. Хавсралт: 4 файл | | |
| 1.3.2 | Сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загварыг боловсруулж батлуулна. | - | Шаардлага, загварын төсөл боловсруулалтын хувь | 30 | 50 | 100 | 2025 оны 06 дугаар сар хүртэл сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загварыг боловсруулж батлуулах чиг үүрэг бүхий албан хаагч томилогдон ажиллаагүй ч гэсэн Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын албан хаагчид журмын эхний төслийг сайжруулан саналаа цаг тухай бүр өгч ажилласан. 2025 оны 06 дугаар сарын 05-нд энэхүү чиг үүргийг хариуцан ажиллах албан хаагчид томилогдон ажиллахаар болсон тул журмыг 2025 онд багтаан батлуулахаар | 50% | 50 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллах болно.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.4. | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ. | - | - | - | - | | Мега төсөл, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилтны судалгаа, холбогдох мэдээллийг загварын дагуу гарган яамдаас 2025 оны 04 дүгээр 18-ны өдрийн 1/1586 тоот албан бичгээр судалгааг авахаар хүргүүлэв. Мөн 14 мега төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилтан, мэргэжилтэн бэлтгэх судалгаа хийх зардал батлах тухай Боловсролын сайдын 2025 оны А/100 дугаар тушаалыг батлуулан БНБТГ-тай хамтран ажиллаж байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг сургалтын байгууллагууд улс, орон нутгийн хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлоготой элсэлтийн бодлогоо төлөвлөх зөвлөмж, чиглэлийг хүргүүлэв. Үүний үр дүнд сургалтын байгууллагууд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бүсчилсэн хөгжил, 14 мега төсөл, “Тэрбум мод”, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо хөдөлгөөн”, “Атрын 4-р аян” зэрэг хөтөлбөр, төслүүдэд шаардлагатай мэргэжилтэй ажилтныг үе шаттайгаар | 100 % | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэх зорилтын дагуу элсэлтийн бодлогоо төлөвлөсөн. Сургалтын байгууллагууд хөдөлмөрийн зах зээлд хамгийн эрэлттэй ХАА мэргэжлээр 2025, боловсруулах үйлдвэрлэлийн мэргэжлээр 848, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 2176 буюу нийт 5049, инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламжийн мэргэжлээр 5037, хосмог сургалтаар Дархан, Налайх, Ховд, Скиллс тех МБС-д 147, олон улсын мэдээллийн технологийн “Pearson btec” хөтөлбөрөөр 466 буюу нийт эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр 24,017 суралцагч суралцаж байна. Мөн “Цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журам”-ыг Боловсролын сайд, Батлан хамгаалахын сайдын 2025 оны 1 сарын 10-ны А/05-А/07 тушаалаар батлуулав. 2025-2026 оны хичээлийн жилээс 21 сургалтын байгууллагад 58 ААНБ-тай хамтран хосмог сургалт хэрэгжүүлж 1636 суралцагчийг хамруулахаар элсэлтийн хяналтын тооны хүсэлтийг ирүүлснийг хянаж байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын 69 байгууллагад 2025-2026 оны хичээлийн жилд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 28,154 суралцагч элсүүлэх элсэлтийн хяналтын тоог боловсруулав. Хавсралт: 5 файл | | |
| 1.4.1 | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ур чадварын шаардлагад нийцсэн хүний нөөцийг дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургуульд бэлтгэнэ. | - | Ажил мэргэжлийн стандартад нийцсэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн эзлэх хувь, Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрөөр хичээллэсэн суралцагчийн тоо (PEARSON BTEC) , Мега төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн чиглэлээр | 12.1 хувь, 300 суралцагч, МбТБ - 7,600 суралцагч | 15 хувь, 400 суралцагч, 7,700 суралцагч | 20 хувь, 550 суралцагч, 7,800 суралцагч | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг сургалтын байгууллагууд улс, орон нутгийн хөгжлийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан шинэчлэн боловсруулж элсэлтийн бодлогоо уялдуулан төлөвлөх зөвлөмж, чиглэлийг хүргүүлэн ажилласан. Сургалт эрхлэх энгийн зөвшөөрөл олгоход хөтөлбөр тус бүрийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг хянаж, санал дүгнэлт гаргаж, нэмэлт зөвлөмж чиглэл өгсөн. Үүний үр дүнд сургалтын байгууллагууд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 мега төсөл, “Тэрбум мод”, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо хөдөлгөөн”, “Атрын 4-р аян” зэрэг хөтөлбөр, төслүүдэд шаардлагатай мэргэжилтэй ажилтныг үе шаттайгаар бэлтгэх зорилтын дагуу элсэлтийн бодлогоо төлөвлөсөн. 2024-2025 оны хичээлийн жилд 69 сургалтын байгууллагад 100 мэргэжлээр 40,906 суралцагч суралцаж байна. Мэргэжлийн | 100 % | 100 % |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчийн тоо | | | | боловсролын сургууль, политехник коллежид хөдөлмөрийн зах зээлд хамгийн эрэлттэй ХАА мэргэжлээр 2025, боловсруулах үйлдвэрлэлийн мэргэжлээр 848, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр 2176 буюу нийт 5049 суралцагч, инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламжийн мэргэжлээр 5037 суралцагч, хосмог сургалтаар Дархан, Налайх, Ховд, Скиллстех мэргэжлийн боловсролын сургуульд 147 суралцагч, олон улсын мэдээллийн технологийн “Pearson btec” хөтөлбөрөөр 466 суралцагч тус тус суралцаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр нийт 24,017 суралцагч суралцаж байна. Элсэлтийн бодлогыг хөдөлмөр зах зээлийн эрэлттэй уялдуулснаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин тогтвортой нэмэгдэж 63.8%-д хүрсэн. Мөн “Цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журам”-ыг боловсруулж Боловсролын сайд, Батлан хамгаалахын сайдын 2025 оны 1 сарын 10-ны А/05-А/07 тушаалаар батлуулсан. Мэргэжлийн болон техникийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсрол сургалтын 69 байгууллагад 2025-2026 оны хичээлийн жилд 28,154 суралцагч элсүүлэх элсэлтийн хяналтын тоог боловсруулав. Хавсралт: 8 файл | | |
| 1.4.2 | Зэвсэгт хүчний тухай хуулийн 13.1.13-д заасны дагуу Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн | - | Журмын төслийн боловсруулалтын хувь | 30 | 100 | - | Зэвсэгт хүчний тухай хуулийн 13.1.13-д заасны дагуу Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална гэсний дагуу тус журмыг Батлан хамгаалахын сайд, Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/05, А/07 хамтарсан тушаалаар батлуулав. Мөн журмын хэрэгжилтийг хангуулахаар 2 яамны харьяа байгууллагуудад хүргүүлэн ажиллаж байна. Хавсралт: 2 файл | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Засгийн газрын гишүүнтэй хамтран батална. | | | | | | | | |
| 1.4.3 | "Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалт-Нийгмийн түншлэл" салбар сурталчлах өдөрлөгийг олон талын оролцоог хангаж Сүхбаатарын талбайд зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | - | 1 | - | "Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалт-Нийгмийн түншлэл" салбар сурталчлах өдөрлөг зохион байгуулах талаар дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд: 1.2025 оны 02 дугаар сарын 17-ны 1/652 тоот албан бичгээр Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрална “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалт-Нийгмийн түншлэл” салбар сурталчлах өдөрлөгийг олон талын оролцоог хангаж Сүхбаатарын талбайд зохион байгуулах талаар санал хүргүүлсэн. Уг албан бичигт санхүүжилтийг шийдвэрлэвэл тус өдөрлөгийг зохион байгуулах боломжтойг дурдсан ч энэхүү арга хэмжээнд төсөв батлагдаагүй тул зохион байгуулах боломжгүй болсон. 2.Ерөнхий боловсролын төгсөх ангийн сурагчид, оюутнууд болон сонирхсон иргэдэд дотоодын болон гадаадын их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн бодит, шууд мэдээлэл олгох, мэргэжлээ зөв сонгоход нь | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэмжлэг үзүүлэх, боловсролын чиг баримжаа олгох зорилготойгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Зангиа ХХК-тай хамтран 2025 оны 05 сарын 19, 20-ны өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд хамтарсан арга хэмжээг зохион байгуулав.Тус арга хэмжээнд УБ хотод мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн 300 орчим суралцагчийг 10 багш удирдан чиглүүлж оролцов. 3. Дэлхийн Аутизмыг таниулах өдөр нь анх 2007 онд НҮБ-аас Аутизмтай хүмүүсийг гадуурхах явдлыг зогсоох, тэднийг хүлээн зөвшөөрүүлэх зорилготойгоор санаачлан зохион байгуулагдаж байсан түүхтэй. Энэ өдрийн хүрээнд “Энэрэл” мэргэжлийн боловсролын сургуулийн тогоочийн ангийн суралцагчид туршлага, өөртөө итгэх итгэл, амьдралд бэлтгэгдсэн байдлаа тайлагнах зорилгоор “Эрүүл Эерэг-Эко Энэрэлтэй өдөр” нэртэй өдөрлөгийг 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Боловсролын яамтай хамтран Монголын театрын музейд зохион байгуулав.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.5. | Боловсролд | - | - | - | - | | Мэргэжлийн болон техникийн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүх хүүхэд, залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудыг хамруулсан, тэдний гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцсэн, тохируулгат орчин, дэд бүтэцтэй, хувилбартай, гэрийн сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгоно | | | | | боловсролын 69 сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 653 суралцагч суралцаж байна. Үүний 389 нь эрэгтэй, 264 нь эмэгтэй суралцагч байна. Энэ нь нийт 40,906 суралцагчийн 1,6 хувийг эзэлж байна. Эдгээр 653 суралцагчийг хөгжлийн бэрхшээлээр нь ангилбал харааны бэрхшээлтэй 145, хэл ярианы бэрхшээлтэй 64, сонсголын бэрхшээлтэй 57, хөдөлгөөний бэрхшээлтэй 123, сэтгэцийн /аутизм, оюуны хөгжлийн/ бэрхшээлтэй 136, дауны хам шинжтэй 188, бусад болон хавсарсан бэрхшээлтэй 110 суралцагч байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.10-т заасны дагуу сургалтын байгууллага нь суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшнийг харгалзан сургалтын хөтөлбөрт тохируулга хийж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохируулан сургалтын хөтөлбөрөө боловсруулан сургалт үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. Мөн сургалтын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан тусгай орц гарц, зориулалтын шат, ариун | % | % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэврийн өрөө зэргийг улс, орон нутгийн болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, дэмжлэгээр хэрэгжүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн 38.0 хувь нь "Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо"-ны дэргэдэх мэргэжлийн боловсролын сургууль, "Энэрэл" мэргэжлийн боловсролын сургууль, Сэргээн Засалт, Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн Мэргэжлийн Боловсрол, Ур Чадвар Олгох Сургууль, Анима политехник коллежид, үлдсэн 62,0 хувь нь бусад 65 сургалтын байгууллагад суралцаж байна. Эдгээр суралцагчдын хувьсах зардлыг холбогдох журмын дагуу энгийн суралцагчийн хувьсах зардлаас 3 дахин нэмэгдүүлэн олгож суралцах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. “Боловсролын сургалтын байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг боловсруулав. Журмыг салбарын мэргэжлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдтэй хамтран хэлэлцүүлж боловсруулсан. Журамд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн эрх, хамгааллын чиглэлээр заалтыг тусгаад байна. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5.1 | Ялгаатай хэрэгцээтэй иргэдийг мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах боломжийг нэмэгдүүлнэ. | 5,514.30, | Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь | 0.7 | 0.7 | 1.5 | Мэргэжлийн болон техникийн боловсролын 69 сургалтын байгууллагад 2024-2025 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 653 суралцагч суралцаж байна. Үүний 389 нь эрэгтэй, 264 нь эмэгтэй суралцагч байна. Энэ нь нийт 40,906 суралцагчийн 1,6 хувийг эзэлж байна. Эдгээр 653 суралцагчийг хөгжлийн бэрхшээлээр нь ангилбал харааны бэрхшээлтэй 145, хэл ярианы бэрхшээлтэй 64, сонсголын бэрхшээлтэй 57, хөдөлгөөний бэрхшээлтэй 123, сэтгэцийн /аутизм, оюуны хөгжлийн/ бэрхшээлтэй 136, дауны хам шинжтэй 188, бусад болон хавсарсан бэрхшээлтэй 110 суралцагч байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.10-т заасны дагуу сургалтын байгууллага нь суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшнийг харгалзан сургалтын хөтөлбөрт тохируулга хийж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохируулан сургалтын хөтөлбөрөө боловсруулан сургалт үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. Мөн сургалтын байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зориулсан тусгай орц гарц, зориулалтын шат, ариун цэврийн өрөө зэргийг улс, орон нутгийн болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, дэмжлэгээр хэрэгжүүлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн 38.0 хувь нь "Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо"-ны дэргэдэх мэргэжлийн боловсролын сургууль, "Энэрэл" мэргэжлийн боловсролын сургууль, Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль, Анима политехник коллежид, үлдсэн 62,0 хувь нь бусад 65 сургалтын байгууллагад суралцаж байна. Эдгээр суралцагчдын хувьсах зардлыг холбогдох журмын дагуу энгийн суралцагчийн хувьсах зардлаас 3 дахин нэмэгдүүлэн олгож суралцах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. “Боловсролын сургалтын байгууллагын хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг боловсруулав. Журмыг салбарын мэргэжлийн нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдтэй хамтран хэлэлцүүлж боловсруулсан. Журамд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн эрх, хамгааллын чиглэлээр заалтыг тусгаад | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна.<br>Хавсралт: 11 файл | | |
| 1.6. | Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны хүртээмж, орчин, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүний эрхэд ээлтэй дотуур байрыг бий болгоно. | - | - | - | - | | 1.Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр 28-ны өдрийн 1/1716 тоот албан бичгээр Сангийн яам руу батлуулахаар хүргүүлсэн "Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын орон тооны хязгаарын жишиг норматив"-ын төсөлд дотуур байрны орон тоо, нэршлийг тусган боловсруулж батлуулахаар хүргүүлэв. 2.Багш, байгууллагын хөгжил хариуцсан шинжээч ажлаа хүлээлгэж өгсөнтэй холбогдуулан мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагын төслийг боловсруулж, нэгтгэн батлуулахаар ажиллаж байна. Одоогийн төлөвлөлтөөр 2025 оны 06 дугаар сарын 05-ны дотор Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын албан хаагчдад танилцуулан санал авахаар бэлтгэж байна. Иймд энэхүү орон тооны жишиг норматив батлагдаж, дараагаар нормативд батлагдсан нэршлийн дотуур байрны багшийн албан тушаалд | 100 % | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тавигдах нийтлэг шаардлага батлагдах уялдаатай ажил юм. 3. Сургалтын агуулга, хөтөлбөр, орчин хариуцсан шинжээчийн орон тооны эзгүйд Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжих төсөлд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудаас дотуур байрын судалгааг сургалтын байгууллагуудаас аван, ирүүлсэн саналыг нэгтгэн Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Пүрэвсайханд 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөөр мэйлээр хүргүүлсэн. Харин Үр дүнд суурилсан зээлийн хөтөлбөр (Азийн Хөгжлийн Банк)-ийн төслийг Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар хариуцан ажиллаж байна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.6.1 | Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны стандарт, техникийн зохицуулалтыг шинэчлэн батлуулж, орон тоог үе шаттай | - | Хүсэлт гаргасан суралцагчдаас дотуур байранд хамрагдсан суралцагчийн хувь, Стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан | 98.6, 77.7, 83, - | 97, 78, -, - | 99, 80, 85, 5 | 1.Боловсролын сайдын 2025 оны 04 дүгээр 28-ны өдрийн 1/1716 тоот албан бичгээр Сангийн яам руу батлуулахаар хүргүүлсэн "Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын орон тооны хязгаарын жишиг норматив"-ын төсөлд дотуур байрны орон тоо, нэршлийг тусган боловсруулж батлуулахаар хүргүүлэв. 2.Багш, байгууллагын хөгжил | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлж, багш, хүний нөөцийн чадавхжуулж, суралцагчид ээлтэй үйлчилгээг нэвтрүүлнэ. | | дотуур байрны эзлэх хувь, Чадавхжуулах сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан дотуур байрны багшийн тоо, Үр дүнд суурилсан зээлийн хөтөлбөр (Азийн Хөгжлийн Банк)-ийн хэрэгжилтийн хувь | | | | хариуцсан шинжээч ажлаа хүлээлгэж өгсөнтэй холбогдуулан мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагын төслийг боловсруулж, нэгтгэн батлуулахаар ажиллаж байна. Одоогийн төлөвлөлтөөр 2025 оны 06 дугаар сарын 05-ны дотор Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын албан хаагчдад танилцуулан санал авахаар бэлтгэж байна. Иймд энэхүү орон тооны жишиг норматив батлагдаж, дараагаар нормативд батлагдсан нэршлийн дотуур байрны багшийн албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага батлагдах уялдаатай ажил юм. 3. Сургалтын агуулга, хөтөлбөр, орчин хариуцсан шинжээчийн орон тооны эзгүйд Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжих төсөлд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудаас дотуур байрын судалгааг сургалтын байгууллагуудаас аван, ирүүлсэн саналыг нэгтгэн Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Пүрэвсайханд 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөөр мэйлээр хүргүүлсэн. Харин Үр дүнд суурилсан зээлийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөр (Азийн Хөгжлийн Банк)-ийн төслийг Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар хариуцан ажиллаж байна. 4.2024-2025 оны хичээлийн жилд 4725 суралцагч хүсэлт гаргаснаас 4586 суралцагч дотуур байранд амьдарч байна. Хавсралт: 5 файл | | |
| 1.6. 2 | Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны стандартыг шинэчлэн боловсруулж батлуулна. | - | Дотуур байрны стандарт боловсруулалтын хувь | ”Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага, MNS 6890:2020” | 0 | 10 | 2025 оны 06 дугаар сарыг хүртэл албан ёсны хариуцсан албан хаагчгүй байсан. Иймд Мэргэжлийн болон техникийн боловсролын стандартыг шинэчлэн боловсруулж "Стандартчиллын 2025-2026 оны төлөвлөгөөнд санал авах тухай"-д саналаа тусган Дээд боловсролын газрын шинжээч Д.Баттогтоход 2026 оны 01 дүгээр сард саналаа хүргүүлсэн бөгөөд тус газраас саналуудыг нэгтгэн албан бичгээр хүргүүлж Стандартчилал хэмжил зүйн Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэхээр болов. | 30% | 30 % |
| 1.7. | Мэргэжлийн ур чадвартай ажилтан, мэргэжилтнийг ахлах сургуулиас эхлэн бэлтгэнэ | - | - | - | - | | Боловсролын сайдын 2025 оны А/188 дугаар тушаалаар мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтын мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийг нарийвчлан тогтоох, сургалтын жишиг хөтөлбөр боловсруулахтай холбоотой зохицуулалтыг мөн тусгасан. Төрөлжсөн ахлах сургуулийг | 100 % | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэргэжлийн боловсролын салбарт мэргэжлийн эрх олгох сургалтын хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулах, багшлах хүний нөөцийг бэлтгэх зэрэг бэлтгэл ажлыг ханган 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэлийг танилцуулах уулзалт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж төрийн өмчийн мэргэжлийн болон политехникийн коллеж, их дээд сургуулийн сургалтын алба, харьяа ахлах сургуулийн захирал, мэргэжилтнүүдийг оролцуулсан. Уулзалтаар төрөлжсөн ахлах сургуулийн онцлог, сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх сургалтын байгууллагыг сонгох чиглэлээр хэлэлцсэн. Мөн Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэлийн төлөвлөгөөг танилцуулах уулзалт хэлэлцүүлэг 2025 оны 05 дугаар сарын 26 өдөр зохион байгуулсан Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэлийг 2025-2026 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах Боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар, Ерөнхий боловсролын газар, Боловсролын ерөнхий газрын хамтарсан уулзалтад оролцож төлөвлөгөөний төсөлд санал өгч оролцсон. Иймд 2025-2026 оны хичээлийн жилээс төрөлжсөн ахлах сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Ерөнхий боловсролын газартай хамтран Боловсролын ерөнхий газарт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Хавсралт: 5 файл | | |
| 1.7.1 | Төрөлжсөн ахлах сургуулийн суралцагчдад мэргэжлийн эрхийн сургалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг ЕБГазар болон холбогдох бусад газартай хамтран хэрэгжүүлж дэмжлэг үзүүлнэ. | 545.10 | Мэргэжлийн эрхийн гэрчилгээтэй төгссөн ахлах сургуулийн суралцагчийн тоо болон арга хэмжээний тоо | - | Арга хэмжээний тоо | -203, -Арга хэмжээний тоо | Боловсролын сайдын 2025 оны А/188 дугаар тушаалаар мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтын мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийг нарийвчлан тогтоох, сургалтын жишиг хөтөлбөр боловсруулахтай холбоотой зохицуулалтыг мөн тусгасан. Төрөлжсөн ахлах сургуулийг мэргэжлийн боловсролын салбарт мэргэжлийн эрх олгох сургалтын хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулах, багшлах хүний нөөцийг бэлтгэх зэрэг бэлтгэл ажлыг ханган 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Төрөлжсөн ахлах сургуулийн талаар | 100 % | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баримтлах чиглэлийг танилцуулах уулзалт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж төрийн өмчийн мэргэжлийн болон политехникийн коллеж, их дээд сургуулийн сургалтын алба, харьяа ахлах сургуулийн захирал, мэргэжилтнүүдийг оролцуулсан. Уулзалтаар төрөлжсөн ахлах сургуулийн онцлог, сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх сургалтын байгууллагыг сонгох чиглэлээр хэлэлцсэн. Мөн Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэлийн төлөвлөгөөг танилцуулах уулзалт хэлэлцүүлэг 2025 оны 05 дугаар сарын 26 өдөр зохион байгуулсан Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэлийг 2025-2026 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар, Ерөнхий боловсролын газар, Боловсролын ерөнхий газрын хамтарсан уулзалтад оролцож төлөвлөгөөний төсөлд санал өгч оролцсон. Иймд 2025-2026 оны хичээлийн жилээс төрөлжсөн ахлах сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Ерөнхий боловсролын газартай хамтран Боловсролын ерөнхий газарт | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>Хавсралт: 6 файл | | |
| 1.8. | Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг ажил олгогчийн шаардлага болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, иргэдийг ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хосмог ажлын | - | - | - | - | | Хосмог сургалт, ажлын байран дахь сургалтыг Дархан, Налайх, Ховд политехник коллеж, Скиллс тек МБС болон “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, Ховд экоцемент ХХК, Оюу толгой ХХК хамтран “Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт”, “Барилгын техник, технологи” ТБ-3 жилийн хөтөлбөрөөр, “Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт”, Цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ, Эрдэс, чулуулаг боловсруулах төхөөрөмжийн ашиглалт, Гагнуур, Уул уурхайн машин механизмын угсралт засвар, үйлчилгээ зэрэг мэргэжлээр хэрэгжүүлж нийт 147 суралцагчийг хамруулж байна. Хосмог сургалтыг салбарын хэмжээнд өргөжүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж сургалтын байгууллага, аж ахуйн нэгжүүдэд зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран үе шаттай зохион | 100 % | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байрны сургалтыг нэвтрүүлнэ. | | | | | байгуулсан. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгох, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэж, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэхэд хосмог сургалтаар мэргэжилтэй ажилтныг бэлтгэх зорилготой ажиллаж байна. Хосмог сургалтын талаар сургалтын байгууллагуудад мэдээлэл өгөх, журмыг танилцуулах уулзалт хэлэлцүүлгүүдийг тогтмол зохион байгуулсны үр дүнд 2025-2026 оны хичээлийн жилээс 21 мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж 58 ажил олгогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран хосмог сургалт хэрэгжүүлж 1636 суралцагчийг хамруулахаар элсэлтийн хяналтын тооны хүсэлтийг ирүүлээд байна. Эдгээр ажил олгогчдын захиалгаар хэрэгжүүлэх хосмог сургалтыг хөдөлмөрийн зах зээлд хамгийн эрэлттэй хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн аж ахуй, барилга, уул уурхай, хүнд машин механизм, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төмөр зам, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжлийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөв. Хавсралт: 3 файл | | |
